

**“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН 2018 ОНЫ
04 ДҮГЭЭР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2018.04.30

Нэг. Зорилго

“ГТХЗНТ” УТУГ-ын бүтцийн нэгжүүдийн 2018 оны 04 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаарх санал, зөвлөмжийг удирдлагад танилцуулах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх зорилготой.

Хоёр. Үндэслэл

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн хяналт-шинжилгээ, үнэлгээний журмыг үндэслэв.

Гурав. Төлөвлөгөөний хэрэгжилт

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэс 12, Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэс 22, Захиргаа, санхүүгийн хэлтэс 23, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд нийт 57 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

Нэгжүүдийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд бүрэн хэрэгжсэн 44, хэрэгжих шатанд 10, хэрэгжээгүй 2, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 1 арга хэмжээтэй, биелэлт **90,0** хувьтай байна.

№	Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажлын тоо	Хэрэгжилтийн байдал /хувиар/					Нэгжийн дүн
			Бүрэн хэрэгжсэн 100 хувь (90-100 хүртэл хувь)	Хэрэгжих шатанд 70 хувь (50-89 хүртэл хувь)	Хэрэгжилт хангалтгүй 30 хувь (10-49 хүртэл хувь)	Хэрэгжээгүй 0 хувь (0-9 хүртэл хувь)	Хэрэгжилт ийг тооцох хугацаа болоогүй	
1	ХЗХБХ	12	8	3	-	-	1	88,18
2	ТМССХ	22	16	5	-	1	-	88,63
3	ЗСХ	23	20	2	-	1	-	92,17
	Дүн	57	44	10	-	2	1	90,00

Дөрөв. Санал зөвлөмж:

Хөдөлгөөн зохицуулалт, хөдлөх бүрэлдэхүүний хэлтэст

1. ЗТХЯ-наас зохион байгуулах “Төмөр замын техник ашиглалтын дүрэм”-ийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт сайтар бэлтгэх, ГТХЗНТ-өөс дүрмийн төсөлд тусгах зохицуулалт, саналыг хамгаалах, тусгуулах;

2. Галт тэрэгний хөдөлгөөний 2018 оны зуны нэгдсэн зурмагийг “Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам”-ын 4.1.2.1-д заасан хугацаанд боловсруулж, батлуулах;

3. ГТХЗНТ-ийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 1.1.2, 2.2.3-т заасан арга хэмжээ, “Хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалт. 3-р хэсэг: Татах хөдлөх бүрэлдэхүүний дугаарлалтад тавих шаардлага. MNS 6630-3:2016 стандарт”-ыг хэрэгжүүлэх, зүтгүүр, илчит тэргийн дугаарлалтыг шинэчлэх ажлыг эхлүүлэх, энэ асуудлаар ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ, ХШҮДАГ-аас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллах;

4. 2018 оны Ү сард хэрэгжүүлэх “Улсын хэмжээнд ашиглагдаж буй хөдлөх бүрэлдэхүүн, салбар замын нэгдсэн тооллого, бүртгэл хийх” ажлын бэлтгэлийг хангах, ЗТХЯ, төмөр замын

байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсгийг Сайд, Төрийн нарийн бичгийн даргын эсхүл төвийн Захирлын тушаалаар байгуулах асуудлыг яамны холбогдох газрын удирдлагатай зөвшилцөж нэг мөр шийдвэрлэх;

Технологи, мэдээлэл, сургалт, судалгааны хэлтэст

5. ГОСТ 33435-2015, Р 54115-2010, О+Р 941 стандартын орчуулга, боловсруулалт, найруулга зүйг хянах, сайжруулах, санал авах үйл явц удаашралтай байгаад дүгнэлт хийж холбогдох байгууллагуудаас санал авахаар хүргүүлэх, санал авах арга хэмжээг 05 дугаар сард зохион байгуулах;

6. Хэлтсийн төлөвлөгөөний №1, 2, 8, 9, 10, 11, 14, 18, 19, 20-д тусгагдсан ажлын биелэлтийг хэт ерөнхий, тодорхой бус гаргасан нь хариуцсан мэргэжилтнээс дахин тодруулах шаардлагатай болдог дутагдал давтагдсаар байна. Иймд биелэлт гаргахдаа ач холбогдол өгч, ажил хэрэгч хандах;

7. ГТХЗНТ-ийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд “тусгай захиалгат” бүтээгдэхүүнээр тусгагдсан “ГТХЗНТ-ийн Техник эдийн засгийн үндэслэл, барилгын зураг төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх”, “ЗТХЯ, ГТХЗНТ, Далайн захиргааны албан хаагчдын орон сууц, Төв, ДЗ-ны оффисын барилгын зураг төслийн ажил боловсруулахад захиалагчийн хяналт тавих, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч, санхүүжүүлэх банкийг сонгож барилга угсралтын ажлыг эхлүүлэх, шаардлагатай техникийн нөхцөлүүдийг авах, инженер геологийн дүгнэлт хийлгэх” арга хэмжээг хэрэгжүүлэх;

Захиргаа, санхүүгийн хэлтэст

8. Хөдөлмөрийн дотоод журмын 1.5-д “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэгдэх, нэмэлт, өөрчлөлт орох тухай бүр нийт ажилтанд танилцуулна.” гэж заасны дагуу “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2018.04.05-ны өдрийн А/23 дугаар тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын нэмэлт, өөрчлөлтийг нийт ажилтанд танилцуулах, төвийн цахим хуудсын “Хууль эрх зүй” цэсний “Дүрэм журам” буланд байршуулах;

9. Төвийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг Захирлын тушаалаар шинэчлэн батлуулах, “ГТХЗНТ” УТҮГ-ын захирлын 2017.04.24-ний өдрийн “Ёс зүйн хороо байгуулах тухай” А/22 дугаар тушаалыг хүчингүйд тооцож, “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийн “Хорооны дарга нь захиргаа санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн дарга байх бөгөөд” гэсэн 6.3 дахь заалтыг өөрчлөн найруулах;

10. Захирлын зөвлөлийн хурлаар 2018 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөний төсөлд нэгжүүдээс санал авч нэгтгэн, батлуулах, хэрэгжүүлэх;

11. Ажилтанд олгох захиргааны чөлөө зөвшөөрөл, гадуур ажлын бүртгэлд хяналт тавих;

Нийтлэг:

12. Улирлаас урт хугацаанд үргэлжлэн хийгдэх ажлыг үе шат бүрд хуваарилан сар тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлэх;

13. Удаашралтай байгаа ажлуудыг “зорилтот түвшин”-д бүрэн хүргэхэд чиглэсэн төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

14. Төмөр замын тээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан 8 дүрэм, журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах арга хэмжээ үр дүнгийн гэрээнд тусгагдаагүй хэдий ч нэмэлт, ажил үйлчилгээнд тооцон ЗТХЯ-нд тайлагнаж үнэлүүлэх

учир ЗТХ-ийн сайдын 2018 оны 13 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж буй төвийн төлөөллүүд идэвх санаачлагатай, ажлын хэсгийн ахлагч нартай эргэх холбоотой ажиллах.

ХЯНАСАН:

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

Т.АРИУНБААТАР

ЗӨВШӨӨРСӨН:

ХЗХБХ-ИЙН ДАРГА

М.БАТМЯГМАР

ТМССХ-ИЙН ДАРГА

Б.ЭНХЖАРГАЛ

ЗСХ-ИЙН ДАРГА

Н.ШИНЭБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ХШҮДАХА

Э.ОСОРЖАМАА